

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 08 сарын 06-ны өдрийн
37 дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ЁС ЗҮЙН ДҮРЭМ**

/Шинэчилсэн найруулга/

ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл	2
Хоёр.Ёс зүйн зарчим, хэм хэмжээ	2
Гурав.Компанийн ажилтны биеэ авч явах зан үйл	4
Дөрөв.Хариуцлага.....	5
Тав.Бусад	5

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “компани” гэх)-ийн үйл ажиллагааг хууль ёсны, ёс зүйд нийцсэн байлгах үүднээс эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын хууль, дүрэм, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоож, түүнийг мөрдүүлэх, хэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр.Ёс зүйн зарчим, хэм хэмжээ

- 2.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэхүү дүрэмд заасан дараах зарчмуудыг баримтлан ажиллана. Үүнд:

2.1.1. Хууль дээдлэх зарчим

- 2.1.1.1.Үйл ажиллагаандаа хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм, журмыг холбогдох бодлого, заавар, аргачлал бусад эрх зүйн актыг мөрдлөг болгон ажиллаж, аливаа хууль бус үйлдэл, эс үйлдэхгүй гаргахгүй ажиллана.

2.1.2. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчим

- 2.1.2.1.Ажил үүргээ гүйцэтгэхдээ аливаа хэлбэрээр ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байж, компанийн ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллана.

- 2.1.2.2.Ажил үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ авах, хууль бус бусад хангамжийг эдлэхгүй.

- 2.1.2.3.Ажилтан, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрхийг хамгаалж, компанийн дүрэм, журмыг баримтлан ажиллана.

- 2.1.2.4.Сонирхлын зөрчлийн талаар тухай бүр мэдэгдэх, сонирхлын зөрчилтэй аливаа хэлцэл, шийдвэр гаргалтад оролцохгүй.

2.1.3. Үл ялгаварлах, эрх тэгш байх зарчим

- 2.1.3.1.Ялгаварлан гадуурхалтаас ангид аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

- 2.1.3.2.Олон талт оролцоо, багийн ажиллагааг хөгжүүлсэн харилцан итгэлцэл, хүндлэл бүхий хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

- 2.1.3.3.Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, харилцагчид хүндэтгэлтэй хандана.

2.1.4. Компанийн нэр хүндийг хамгаалах зарчим

- 2.1.4.1. Компанийн нэрийн өмнөөс аливаа гуравдагч этгээдтэй харилцахдаа ёс зүйн хэм хэмжээг чанд сахин ажиллана.

- 2.1.4.2. Компаниас хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх, ярилцлага хийх тохиолдолд Гүйцэтгэх захиралд танилцуулж, зөвшөөрөл авна.

- 2.1.4.3. Компанийн ажилтнууд үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхдээ компанийн нэр хүнд, бие даасан, хараат бус байдлыг эрхэмлэнэ.
- 2.1.4.4. Ажилтны хэлэх үг, нийтлүүлэх өгүүлэл, материал нь компанийн нэр хүнд, бие даасан байдалтай харшлахгүй байх бөгөөд ажилтан аливаа нийгэм соёлын арга хэмжээнд оролцсоноор компанийн нэр хүндэд харшлахаар бол түүнд оролцохоос татгалзана.
- 2.1.4.5. Ажилтан өөрийн үзэл бодол, таамаглалаа компанийн бодлого, байр суурь хэмээн хамт олон, иргэд, олон нийтэд ухуулахгүй.
- 2.1.4.6. Ажил үүргээ гүйцэтгэхдээ компанийн ажил хэргийн нэр хүнд, нийтийн ашиг сонирхол, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй.
- 2.1.4.7. Төрийн эрх бүхий байгууллагатай харилцахдаа хууль, дүрэм, журамд заагаагүй хөлс төлөхийг санал болгох, авлига, хахууль өгөхгүй.

2.1.5. Компанийн нууцыг хамгаалах зарчим

- 2.1.5.1. Компанийн нууц мэдээлэл болон ажил, үүргийн дагуу олж мэдсэн хүний хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй бөгөөд холбогдох хуульд заасны дагуу хамгаалан ажиллана.
- 2.1.5.2. Хамтран ажиллаж байгаа ажилтнуудын хувийн мэдээлэл, цалин хөлс, нэмэгдэл, урамшуулалтай холбоотой мэдээллийг нууцална.
- 2.1.5.3. Дотоод мэдээллийг аливаа байдлаар ашиглахгүй, бусдад тарааж, дамжуулахгүй, дотоод мэдээлэл эзэмшигчийн хувьд хүлээх үүргийг биелүүлж ажиллана.

2.1.6. Ил тод, нээлттэй байх зарчим

- 2.1.6.1. Хууль тогтоомж, дүрэм, журамд олон нийтэд нийтлэхээр заасан мэдээллийг компанийн цахим хуудас болон шаардлагатай бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан тухай бүр үнэн зөвөөр олон нийтэд мэдээлж ажиллана.
- 2.1.6.2. Дотоод болон хөндлөнгийн аудит бусад хяналт, шалгалтын байгууллагад зөвхөн үнэн зөв мэдээллийг өгч хамтран ажиллана.
- 2.1.6.3. Аливаа эерэг шинэчлэл, өөрчлөлтийг шуурхай хүлээн авч хэрэгжүүлэх, түүнд хурдан дасан зохицох, шинийг эрэлхийлэн идэвх санаачилгатай ажиллана.

2.1.7. Ажил үүргээ шударгаар гүйцэтгэх зарчим

- 2.1.7.1. Ажил үүргээ гүйцэтгэхдээ өөрийн мэдлэг, ур чадвараа дайчлан, мэргэжлийн өндөр түвшинд үнэнч шударгаар үүргээ биелүүлж ажиллана.
- 2.1.7.2. Хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж, өгөгдсөн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд судалж, санал, дүгнэлт, танилцуулга боловсруулах, үндэслэлтэй, үнэн зөв, бодит мэдээллээр удирдлагыг хангана.
- 2.1.7.3. Ажил үүргээ гүйцэтгэх явцад алдаа, дутагдал гарвал энэ талаар нэн даруй удирдах ажилтандаа мэдэгдэх ба алдаа, дутагдлыг нуун дарагдуулах аливаа үйлдэл гаргахгүй.

2.1.8. Улс төрийн нөлөөллөөс ангид байх зарчим

- 2.1.8.1. Удирдлагадаа байгаа болон бусад ажилтныг улс төрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, оролцох санал тавих, улс

төрийн сонирхлоо тулгахыг хориглоно.

2.1.8.2. Улс төрийн албан тушаалд томилогдох, нэр дэвших бол энэ талаар урьдчилан компанид мэдэгдэнэ.

2.1.8.3. Компанийн өмнөөс аливаа улс төрийн байр суурь илэрхийлэх, мэдэгдэл гаргахгүй байх.

2.2. ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 2.1-т зааснаас гадна дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

2.2.1. Өөрийн эрх, үүргийг бүрэн хэрэгжүүлэх зарчим

2.2.1.1. Хууль тогтоомж, компанийн дүрэм болон ТУЗ-ийн шийдвэрээр тогтоосон эрх, үүргийг энэхүү дүрэмд заасан ёс зүйн зарчим, хэм хэмжээнд бүрэн нийцүүлэн ажиллана.

2.2.1.2. Аливаа асуудлыг шийдвэрлэхэд байнга зөвийг эрхэмлэн дээдэлж, асуудалд үндэслэлтэй, шударга хандана.

2.2.1.3. Өөрийн удирдлагад ажиллаж буй ажилтантай ажил хэрэгч, хүндэтгэлтэй харилцах ба удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

2.2.1.4. Ажилтнуудад ажил үүргийг тухайн ажилтны чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтын дагуу шударга, тэнцвэртэй хуваарилж, ажлын гүйцэтгэлийг шударгаар үнэлнэ.

2.2.2. Хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах зарчим

2.2.2.1. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдыг хүндэтгэн түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, ажил хэрэгч харилцаж, тэдэнд хүндрэл чирэгдэл учруулалгүй түргэн шуурхай ажиллана.

2.2.2.2. Хүсэлт, гомдлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авах, хариу өгөх, бие даан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд эрх бүхий этгээдээр шийдвэрлүүлэн хариуг мэдэгдэж ажиллана.

2.2.3. Аливаа нөлөөллөөс ангид байх зарчим

2.2.3.1. Компанийн аливаа шийдвэр, үйл ажиллагаанд хувийн сонирхлоор хандахгүй, албан тушаалын давуу байдал үүсгэхгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

2.2.3.2. Компанийн эрх ашигт шууд болон шууд бусаар сөргөөр нөлөөлж болохуйц аливаа нөлөөллөөс ангид байна.

Гурав. Компанийн ажилтны биеэ авч явах зан үйл

3.1. Ажилтан ажил үүргээ гүйцэтгэхдээ дараах шаардлагыг биелүүлж ажиллана. Үүнд:

3.1.1. хамтран ажиллагсдаа хүндэтгэж, өөр хоорондоо нөхөрсөг, шударга, хамтач, ажил хэрэгч харилцаатай байх;

3.1.2. ажлын чиг үүргийн дагуу харилцагч, хамтран ажиллагсадтай харилцахдаа ёс бус үг хэллэг ашиглахгүй, доромжлохгүй байх;

3.1.3. ажлын чиг үүргээр бусадтай харилцахдаа үнэн зөв мэдээлэл өгөх;

3.1.4. хамт олны дунд элдэв хов жив, цуу яриа, доромжлол, хэрүүл маргаан үүсгэхгүй, худал мэдээлэл тараахгүй байх;

3.1.5. ажил хэрэгч хувцаслаж, ажлын байрны эмх цэгцийг хангах.

3.2. Ажилтанд ажлын байранд дараах үйлдлийг хориглоно. Үүнд:

3.2.1. согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, сурталчлах, тараах үйл ажиллагаа явуулах, тамхи татах;

3.2.2. ажлын цагаар ажлын байраа зөвшөөрөлгүйгээр орхиж явах;

3.2.3. ажил үүрэг гүйцэтгэхтэй нь холбогдуулж компаниас олгосон хөрөнгийг

хувийн зорилгоор ашиглах.

3.3. Компанийн ажилтанд дараах үйлдэл, эс үйлдэхүйг хориглоно. Үүнд:

- 3.3.1. танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садны хүмүүс ажиллаж байгаа байгууллагад хяналт, шалгалт хийх, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, тендер шалгаруулалтад оролцох, тендер шалгаруулагчийн шийдвэрт нөлөөлөх, үйлчилгээ авах, гэрээ хэлцэл байгуулах, албан тушаалын нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглах;
- 3.3.2. харилцагчаас бэлэг, мөнгө, шагнал, хандив, эд хөрөнгө болон өөрт ашигтай аливаа туслалцаа, үйлчилгээ авах;
- 3.3.3. компанитай ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг болон өрсөлдөгч байгууллагад ажиллах, гишүүнээр элсэх, зөвлөхөөр ажиллах, үйлчилгээ үзүүлэх;
- 3.3.4. албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, хамт ажилладаг ажилтнуудыг болон бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгах;
- 3.3.5. бусад ажилтнуудын үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, нөлөөлөхийг оролдох, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөх;
- 3.3.6. ажил үүргийн хувьд нэг нь нөгөөдөө шууд захирагдах буюу хяналт тавих албан тушаалтан нь гэр бүл, төрөл садны хүнтэй нэг газар, хэлтэс, албанд хамт ажиллах, түүнийг албан тушаалд дэвшүүлэх, дотоод, гадаадын сургалтад сонгон шалгаруулах, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оролцох;
- 3.3.7. компанийн нэр, лого бусад таних тэмдгийг гүйцэтгэх захирлын зөвшөөрөлгүйгээр ашиглах.

Дөрөв.Хариуцлага

- 4.1. Ажилтнууд ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэх захирлын тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.
- 4.2. ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-өөс томилогддог ажилтнуудтай холбоотой ёс зүйн зөрчлийн талаар ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны гаргасан дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн арга хэмжээ авна. Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 4.3. Ажилтны ёс зүйн зөрчил нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

Тав.Бусад

- 5.1. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт, илэрсэн ёс зүйн зөрчил, тэдгээрийг шийдвэрлэсэн явцыг Төлөөлөн удирдах зөвлөл тогтмол хугацаанд хянаж, дүрэмд шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтийг хийнэ.
- 5.2. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэх, шалган шийдвэрлэхтэй холбоотой харилцааг тухайлсан журмаар зохицуулна.

---o0o---